

ТАВАН ШАЛТГААНЫ ҮР

П.Даваанил¹

Чү. Гоо

Түлхүүр үг: Шалтгаан, үр дагавар, хэрэг тус, хилэнц нүгэл

Оршил

“Хөгжмийн шастирын тайлбар”²-т хөгжмийг туурвихын хэрэг тус нь “Сүсэг төгөлдөр бодгалууд чухаг дээд [Бурхан, ном, хувраг]-д тахил өргөх, идээ эдийг хүсэгчид идээ тэргүүтнээр амьдрах, тачаалтан өөр бусад хүний сэтгэлд тачаасан орныг хөдөлгөх тэр бүгд хоёр хөгжмийн [хамт төрсөн хөгжим, бусад шалтгаанаас гарсан хөгжим] тийн агуулгад мэргэжсэнээс гарна, бусдаас гарахгүй” гэжээ. Хэрэв эс мэргэжвээс өөртөө зовлон хураах, бусдын доог тохуу болох, цаашлаад шашины уншлага зан үйлийн тухайтад нүгэл хилэнцэд тооцогдох тул эс дуулах, эс хөгжимдөх нь хавьгүй дээр билээ. Эдгээр үл зохилдох зүйлсийг эл сурвалжид “Таван шалтгаан” /Тө: *rgyu lnga*/ хэмээн нэрлэж тайлбарлажээ. Орчин цагт яг ингэж нэрлэсэн нь үгүй ч дуулах урлагийн багш, судлаачид өөрийн ажиглалт, туршлага дээрээ үндэслэн үүнтэй төстэй санал, зөвлөмжийг хэлсэн нь багагүй байна. Гэвч харьцуулан судалсан судалгаа байхгүй байна. Тиймээс дуучид, дуулах урлагийн багш нарын санал, зөвлөмжийг уг “Таван шалтгаан” гэх ойлголттой харьцуулан үзэж юуг авах, юуг орхих нь зохилтойг тайлбарлахыг зорьлоо. Мөн зарим дуучны гэмийг жишээ болгон орууллаа.

Үндсэн хэсэг

Одоо “Хөгжмийн шастирын тайлбар”-ын хэддүгээр бүлгийн аль хэсэгт таван шалтгааны тухай өгүүлснийг сийрүүлэе. Хөгжмийн шастирын тайлбар зохиол нь

1. Эхлэлийн үг
2. Тархины утга
3. Номын утга
4. Төгсгөлийн утга
5. Төгсгөлийн үг гэсэн үндсэн таван хэсэгтэй бөгөөд гол гурван бүлэгтэй (Зураг 1).

¹ “Хятад, Монгол хоёр орны хил дамнасан соёлын орчин дахь Монгол бурхны шашны хөгжмийн харьцуулсан судалгаа” сэдэвт БНХАУ-ын Боловсролын яамны залуу эрдэмтний төслийн хүрээнд бичсэн өгүүлэл. Төслийн дугаар 16YJC760008

² Сажа бандид Гунгаажалцаны /1182—1251/ “Хөгжмийн шастир”-ыг Сажын ёсны ширээт Агваангунгаасодномын /*ngag dbang kun dga' bsod nams* 1597-1659/ хожим тайлбарласныг бид “Хөгжмийн шастирын тайлбар” /*rol mo'i bstan bcos kyi 'drel pa*/ хэмээн нэрлэдэг. Угтаа энэ зохиолын нэр нь “Хөгжмийн шастир саруул, оюунтны сэтгэлийг булаагч үйлсийг огоотод түгээгч” буюу “*Rig pa'i gnas lnga las bzo rig pa'i rol mo'i bstan bcos kyi nam par bshad pa 'jam dbyangs bla ma dges-pa'i snyan pa'i sgra dbyangs blo gsal yid 'phrog phrin las yongs khyab ces bya ba bzhugs so*” гэх нэртэй юм.

Үүний 3 дахь нь буюу “Номын утга” нь дотроо гурван бүлэгтэй. Эхний бүлэг нь “Эгшгийн тийн агуулга”, хоёрдугаар бүлэг нь “Үгийн тийн агуулга”, гуравдугаар бүлэг нь “Эгшиг, үгийг найруулах ёс” юм. Үүний гуравдугаар бүлэг буюу “Эгшиг, үгийг найруулах ёс” нь зургаан хэсэгтэй. Түүний нэг нь “Мэргэд бүгд орох ёстой уддисыг номлох” хэмээх болой. Энэ нь дотроо хоёр зүйл бөгөөд үүний “Увдис бодитойг дэлгэрэнгүй номлох” гэх хэсэг нь дөрвөн зүйл байна. Үүний гурав дахь нь “Төгсгөлд нь таван шалтгааны үүднээс уддислана” гээд шоолохын шалтгаан (1), уйсахын шалтгаан (2), хилэнц хураахын шалтгаан (3), хочлохын шалтгаан (4), зовлон үүсгэхийн шалтгаан (5)-ыг тус тусад нь тайлбарлажээ. Одоо эдгээр ойлголтын сурвалжид буй тайлбарыг дуучид, дуулах урлагийн багш нар, хөгжим судлаачдын тайлбартай харьцуулж үзье. “Хөгжмийн шастирын тайлбар”-аас авсан хэсгээ *mod (Bold)*, *налуу (Italic)* үсгээр тэмдэглэлээ.

Хочлохын шалтгаан: /Тө: *brnyas pa'i rgyu*/. “Эгшиг, үг хоёрт мунхарваас мэргэн, тэнэг бүгд бээр хочлохын шалтгаан” гэжээ. Товчдоо эгшиг авианы гэм, үгийн гэм үйлдэхийг хэлж байна. Тодруулбал, энэхүү таван шалтгааны өмнө “Бодит хэсэгт нь зургаан гэмийн үүднээс уддислана” гэсэн байгаа бөгөөд “Эгшиг заримдаа их, заримдаа бага, хэт арвижуулах, хэт хомсдуулах, бие хэлээ дэлдэх, хэтэрхий хурдлах, хэтэрхий удаашрах, хоолойгоо шахаж албадах, хоолойны өнгөө засварлах зэрэг нь авианы гэм мөн, Үгээ дутуу хэлэх, дахин дахин давтах, хэрэггүй сул үгтэй байх, үг үсэг нь тодорхой биш, үгийн тасалгааг эндүүрсэн эдгээр нь үгийн гэм мөн” (Гантөмөр, 2014:68) хэмээн тодорхой өгүүлсэн байна. Үгийн таслах завсрыг нь эндүүрсэнээс утгын алдаа гаргах нь түгээмэл. Хэдэн жишээ дурдъя. Соёлын гавъяат зүтгэлтэн П.Батсайханы шүлэг, Урлагийн гавъяат зүтгэлтэн Д.Цэвээнравдангийн ая “Ээж минь” дууг Монгол улсын гавъяат жүжигчин, дуучин С.Батсүх³, дуучин Д.Нямжав⁴ нар дуулжээ. Энэ дууны шүлэг дэх “Төрдөг” гэдэг үгийн таслах завсрыг нь эндүүрэн үгийн нэгдүгээр үеийн “Ө” эгшгийг уртаар дуудахад “Төөрдөг” болж утга нь алдагдаж байна. Монгол улсын соёлын гавъяат зүтгэлтэн Ж.Бадраагийн шүлэг, Монгол улсын урлагийн гавъяат зүтгэлтэн С.Гончигсумлаагийн ая “Жаргаах зүрхэн” дууг Ардын жүжигчин, дуучин Б.Зангад⁵, Монгол улсын гавъяат жүжигчин, дуучин Д.Сосорбарам⁶, соёлын тэргүүний ажилтан, дуучин Б.Маралжингоо⁷ тэргүүтэй олон дуучид дуулжээ. Б.Зангад, Б.Маралжингоо нар энэ дууны “Хүрэн” гэдэг үгийн таслах завсрыг нь эндүүрэн нэгдүгээр үеийн “Ү” эгшгийг уртаар дуудсанаас болж “Хүүрэн” гэсэн буруу хазгай үгийн дуудлага сонсогдож байна. Хэдийгээр бид хам утгынх нь хүрээнд яавч “Хүүрэн” биш гэдгийг нь мэдэж байвч учир мэдэхгүй балчир хүүхэд аль эсвэл монгол хэл сурч буй гадаадын иргэн энэ үгийг дуудлагаар нь хүлээн авч сонсохыг байг гэх газаргүй. Харин Д.Сосорбарам “Хүрэн” хэмээн зөв дуудан дуулж байгаагаас үзвэл дууныхаа үгийг чамгүй сайн судалдаг дуучин болох нь харагдаж байна. Ер нь Д.Сосорбарам дуулсан дуунуудынхаа үгийг зөв газар нь таслаж дуулдаг болох нь бусад дуунуудаас нь ч илэрхий ажиглагдаж байна. Үүнийг залуу дуучид анхаарч сонсвол зохилтой. Мөн Монгол ардын дуу “Хүрэн толгойн сүүдэр”-ийг Монгол улсын соёлын тэргүүний ажилтан, дуучин Б.Мөнхбаатар⁸, Монгол улсын гавъяат жүжигчин, дуучин Д.Долгоржав⁹, дуучин Б.Лхамжав¹⁰, дуучин Л.Идэрбат¹¹, ӨМӨЗО-ны дуучин Найрамдал¹² тэргүүтэй дуучид дуулжээ. Энэ дууны “Хүрэн” гэдэг үгийг Б.Мөнхбаатар “Хүрэн” хэмээн зөв дуудан дуулж байна. Харин

³ https://www.youtube.com/watch?v=FrG110VXo_U 2019. 10. 24

⁴ <https://www.youtube.com/watch?v=L1s7VLA9pEI> 2019. 10. 24

⁵ <https://www.youtube.com/watch?v=KE83aWBm3PE> 2019. 10. 26

⁶ <https://www.youtube.com/watch?v=SSq-oYIIZwk> 2019. 10. 26

⁷ <https://www.youtube.com/watch?v=gMexQ8v3zX4> 2019. 10. 26

⁸ <https://www.youtube.com/watch?v=0cquui0LM0> 2019. 10. 26

⁹ <https://www.youtube.com/watch?v=Wj8pGO4peCY> 2019. 10. 26

¹⁰ <https://www.youtube.com/watch?v=B7CNQSRSDUQ> 2019. 10. 26

¹¹ <https://www.youtube.com/watch?v=HftrBXMyygm> 2019. 10. 26

¹² <https://www.youtube.com/watch?v=jRwYHLUIYIA> 2019. 10. 26

Д.Долгоржав, Б.Лхамжав, Л.Идэрбат, Найрамдал нар “Хүүрэн”, “Хүүрэн” хэмээн буруу дуудаж байна. Нэг талаас нутаг нутгийн аялгуу өөр өөрийн гэсэн өвөрмөц онцлогтойн дээр эгшиг томолт байна гэж үзэж болох ч “Хүрэн” гэх үгийн “Ү”, “Э” эгшгэн дээр эгшиг томох нь төдийлөн оновчтой биш байна. Өөрөөр хэлбэл монгол хэлний “Х”, “Н” гийгүүлэгч эгшиг томоход өвөрмөц чухал үүрэг гүйцэтгэдэг. Дээрх тохиолдолд “Хүрэн” гэдэг үгийн сүүлийн хамаршсан “Н” гийгүүлэгч дээр эгшгийг үргэлжлүүлэн дуурьсгах нь илүү зохимжтой байна. Цаашлаад үгийн оногдсон утгыг зөв дуулах нь дуучин хүний эрхэмлэн сахих ёс гарцаагүй мөн тул аль зохимжтойг нь шинжлэн үзэх хэрэгтэй. Энэ мэт жишээ дурдвал хэмжээлшгүй олон байна. Гагцхүү учир юу вэ гэвэл иймэрхүү алдаа ихэвчлэн богино эгшгийг урт болгож дуудсантай холбоотой илэрч байна. Өөрөөр хэлбэл “Төрдөг”, “Хүрэн” гэх үгсийн нэгдүгээр үеийн “Ө” болон “Ү” эгшгийг уртаар дуудахад түүний дуудлага нь өөр утга бүхий үгтэй таарах тохиолдолд ийм алдаа гарч байна. Харин ингэж уртаар дуудсан ч тэрхүү дуудлага нь өөр утга бүхий үгтэй дүйхгүй тохиолдолд нэг их анзаарагдахгүй хэдий ч дуучид үүнээс аль болох зайлхийх хэрэгтэй. Үгийн завсар нь эндүүрэгдсэнээс болоод олон хөгтэй, шогтой тохиолдол гардаг бөгөөд олны ам дамжин яригдах нь цөөнгүй. Бүр түүгээрээ хочлогдох, овоглогдох нь ч бий. Тиймээс сайтар судлан, ойлгож байж дуулах нь чухал.

Шоолохын шалтгаан: /Тө: bzhad gad rgyu/. “Эгшгийн найруулга үгүй аваас мэргэд шоолохын шалтгаан” болно гэжээ. Энд бид эгшгийн найруулга гэж юу болохыг “Хөгжмийн шастирын тайлбар” зохиолын өмнөх бүлгээс тодруулах хэрэгтэй болж байна. Уг зохиолын 3 дугаар бүлэгт эгшиг, үгийг найруулах ёсыг тусгайлан номлосон байдаг. Ингэхдээ эгшгийг эгшигтэй хэрхэн найруулах вэ, эгшгийг үгтэй хэрхэн найруулах вэ, үгийг үгтэй хэрхэн найруулах вэ гэдгийг нарийвчлан зааж өгчээ. Ингэхлээр эгшиг, үгээс хамаарсан маш олон хувилбар найруулга байх боломжтой бөгөөд тэдгээр нь мөн тус тусдаа өөр өөрийн гэсэн сайн муу, зөв буруу найруулга үүсгэх боломжтой байна. “Манай Монголын газар газраас дууны аялгуу тэр бүр завсраа харилцан адилгүй мэт боловч тэндэх ану зөв эндэх ану буруу хэмээх зүйл үгүй дор бүрнээ уран сайхны талаар уялдсан. . . ” (Дугаржав М. 2008:250) байдаг нь тус бүртээ ая хөг, найруулгын зохистой төлөвөө олсон хэрэг. Харин үүнийг үзэгч олон эсвэл сүсэгтнүүднийн сонорт хүргэхэд дуучны эсвэл унзадын хоолойн цараа, арга барил, ур чадвар маш чухал нөлөөтэй. Гагцхүү олонд таашагдах уу, шоолуулах нь уу гэдэг нь тэдний тухайн үеийн гүйцэтгэлээс хамаарах бөгөөд дуучин болон унзадаас олон талын мэдлэг туршлага, авъяас, ур чадвар, судалгаа шаардана. Уртын дуучин М.Дугаржав “Үндэсний дуу хөгжмийг хэрхэн мандуулах тухай” өгүүлэлдээ “Аливаа дууны аялгууг чихний сонор сайхан мэдрэлээр татаж тархи ухааны уран сайхны мэдрэл дор тогтоох, хоолойн донж гоё сайхан мэдрэлээр үгний хуваарь хэмжээ хийцийг чимэглэн гаргасны хойно сая энэ гурван уран нийлээд яруу найруулга бүхий уран сайхан аялгуу бүрдэж чадмой” (Дугаржав М. 2008:250) хэмээснийг сайтар санах хэрэгтэй.

Уйсахын шалтгаан: /Тө: skyo ba'i rgyu/. “Цагийн хэмжээ үгүй юм уу эс мэдвээс эгэл хүмүүс уйсахын шалтгаан” мөн. Цагийн хэмжээ үгүй гэдэг нь хэмжээ, хэмнэлгүй байхыг хэлж байна. Хэмнэл буюу ритм гэдэг нь “Эгшгийн хөдөлгөөнийг хугацаагаар ялгах үзэгдэл. Ямар нэг үйл явцыг цаг хугацаатай тусгаж авах хэлбэр. Хөгжмийн шинжлэх ухааны онолын чухал хэсэг”, Хэмжээ буюу размер гэдэг нь “Хөгжмийн тодорхой нэгжийг баримталсан хөгжим, яруу найргийн хэмнэлийн байгууламж. Хэмжээ нь хөгжимд айзмыг бий болгоно. Хэмжээний журамд олон янзын хэм багтана. 2/4. 3/4. 6/8. 5/8 г. м. ” (Жанцанноров Н. 1996:79:81). Тэгэхээр ямар ч дуу, хөгжим тодорхой айзамтай бөгөөд түүнийг эс баримталбаас хүмүүс уйдаж, дургүйлхэж эхэлдэг. “Харин нийт олноороо дууны аялгууны чимээ, сонсголонгийн уран чимэг, эгшиг найруулгын хуваарийг тэнцүүлэн наадваас сая уран сайхны нэгдэл болох амой. Хэрэв эл журмыг үл хэрэгсэн хэн хүн чиг чигтээ өөрсдийн зоргоор тоглобоос хоорондын атаа тэмцлийн чанартай бөгөөд уран сайхны бус болно” (Энэбиш, 2008:254). Иймээс дуу, аялгууг оноосон хэмнэлд нь тохируулан яруу

сайхан тоглож, чимэглэх хэрэгтэй. Баяжуулж, хөгжүүлж, шинэчилж байгаа нь энэ гээд уг мөн чанар, хэмжээг нь алдагдуулж үл болно. Монгол улсын консерваторид 2011 оноос хойш багшилж байгаа японы дуурийн дуучин, дуулах урлагийн багш Окуяама Юми “Хэмжээний мэдрэмж сайтай монгол хүүхдүүд ховор. Яагаад гэвэл багаасаа суралцаагүйтэй холбоотой. Ерөнхийдөө цэцэрлэгийн наснаас нь эхлээд хөгжмийн мэдрэмжтэй болгох хэрэгтэй. Наад тал нь 10 наснаас нь өмнө эхлэх хэрэгтэй”¹³ гэсэн юм. Тиймээс бид тусгай мэргэжлийн сургуулийн сурагчдыг бүр бага наснаас нь сонгон авч суралцуулах хэрэгтэй.

Нөгөө талаас дуу, аялгууг хэмжээ, хэмнэлд оруулах нь сэтгэлд нийцтэй төдийгүй, өгүүлэхэд хялбар болдог хэмээн “Их хүрээний ая эгшгийн уг гарал”-д дурдсан байна. Түүнийг энд сийрүүлбэл, “Тэр мэт татахын цагт шүлэг болон үгийн тасалбаруудад ч гэсэн суралцдаг. Үргэлжилсэн үгэнд уртавтар үйлддэгт нь суралцдаг бөгөөд тус тусын хувьд ялгаж үйлдэхийн тул болой. Тэр цагт машинд гүймэг шулуухан болох тул татахын хувь зохилдлого хялбар болдог. Тэр мэт хэрвээ эс үйлдвээс гурван үүд¹⁴ дав дав дэгэн догон болох бөгөөд сонголонгүй, үзэсгэлэнгүй болно хэмээсэн ба тиймээс алгуурхан үйлдэх, амьсгаагаа дуустал гүйцэд үйлдэхэд суралцах хэрэгтэй юм. Ингэж алгуур амьсгаагаа тохируулж хувь таслах энэ нь өөрийн бие махбодод нь зовиургүй бөгөөд сэтгэлд нийцтэй зохимжтой хэмээх тэргүүтэнд суралцах хэрэгтэй” (Төвөд гар бичмэл, 561-6a1) гэжээ. Энэ үүднээс нь харах юм бол хэмжээ, хэмнэлд зохируулах нь тухайн дуучин (унзад)-ы биед зовиургүй төдийгүй бусдыг сэтгэлийг татах, тогтоон барих цалам болдог ажээ.

Хилэнц хураахын шалтгаан: /Тө: *sdig pa'i rgyu*/. “Чухаг дээдийг тахих тэргүүтний хэрэг байхгүйгээр дэмий чалчаа эгшигийг үйлдвэл хилэнц хураахын шалтгаан” болно. Энд нэн тэргүүнд “чухаг дээд” хэмээх нь юу болохыг тайлбарлах хэрэгтэй. Энгийн ярианд “чухаг дээд”, “чухаг дээд гурав”, “ээ гончигсүм минь” гэх мэтээр хэлэлцдэг. Угтаа бурхан, ном, хувраг гурвыг нэрлэж байгаа хэрэг юм. Ингэхлээр буддын шашинд эдгээрт ая эгшиг өргөх, сүсэглэх, тахихаас бусдаар ая эгшиг үүсгэхийг таашаадаггүй бөгөөд “Жил, сарын дөрвөн их дүйчэн өдөр, багшийн их дүйчэн тэргүүтний үед болно” (Гантөмөр. 2014:22) гэж бүр тодорхой хугацаа зааж өгсөн бий. Хэрэв ая эгшиг, наадам цэнгээн нь ихэдвэл сахил санваараа алдаж, сэтгэл нь тогтохгүй алгасарч, хичээл шамдал нь үгүй болж нүгэл хилэнц хураах гэмтэй гэж үздэг ажээ. Мөн дэмий чалчаа эгшиг гэснийг ч нягтлах хэрэгтэй болж байна. Учир нь хөгжмийн онолд дэмий чалчаа эгшиг гэх ойлголт байхгүй. Харин энгийн ярианд ч тэр, шашинд ч тэр дэмий чалчаа гэж хэлэх нь бий. Энэ нь хөгжмийн ухааны үүднээс эмх замбараагүй, хэрэггүй сул, онцын шаардлагагүй буруу зөрүү ая эгшгийг хэлж байна. Ийм ая эгшиг найруулгыг нь сулруулж, утгыг нь эндүүрүүлж төөрөгдүүлэх гэмтэй. Харин шашны талаасаа сахил санваар зөрчсөн, доройтуулсан, ёс журам алдагдуулсан, буян үйлдэхээс өөр бусад үүдэлтэй шаардлагагүй, хэрэггүй ая эгшгийг хэлж байна. Тийм ч учраас нүгэл хилэнцийн уг шалтгаан болно гэж үздэг байна.

Зовлон үүсгэхийн шалтгаан: /Тө: *sdug pa'i rgyu*/. “Эгшигийг сонсогч олон мэргэд хурсан болон олон төрөлхтөн хүрээлсэн газарт өөртэй нь өрсөлдөх муу нөхөртэй тэмцэлдэн үйлдэх хийгээд цугласны дунд өөрөө эгшигийг судалсан нь бага, самбаа нь сул, хамт төрсөн оюун муу бол өөртөө зовлон үүсгэхийн шалтгаан мөн” гэжээ. Үүнийг тус бүрт нь задлан тайлбарлая. Эгшгийг сонсогч олон мэргэд хурсан болон олон төрөлхтөн хүрээлсэн газарт дуу эгшиг үүсгэхдээ маш сайн бэлтгэх хэрэгтэй. Учир нь чамаас илүү мэдлэг, ур чадвартай хүмүүсийн дунд буруу, зөрүү дуулж, хөгжимдөх нь бусдыг баясгах бус өөртөө зовлон хураана гэдгийг хэлсэн хэрэг. Өөртэй нь өрсөлдөх муу нөхөртэй тэмцэлдэн үйлдэх нь мөн буруу гэжээ. Ая эгшиг өргөх нь бусдыг цэнгүүлэх, баясгахын тулд учраас хэн нэгэнтэй өрсөлдөн тэмцэлдэхийн тулд хэрэглэх нь мөн зовлонгийн шалтгаан болно. Ер

¹³ 2019. 10. 22-нд Монгол улсын консерваторийн гурван давхарт, 316 тоот өрөөнд дуурийн дуучин, дуулах урлагийн багш Окуяама Юми-тай хийсэн ярилцлага. Тэрбээр Японы Токиогийн консерваторийг төгсөж, БНХАУ-ын Бээжингийн төв консерваторид мэргэжил дээшлүүлжээ.

¹⁴ Бие, хэл, сэтгэл

нь эгшиг үүсгэх, дуулах, хөгжимдөхөд үл зохилдох зүг нь олон бол тэвчих хэрэгтэй ажээ. Харин өөрөө дуу эгшгийг сайтар эзэмшсэн хийгээд дуулах, хөгжимдөхөд үл зохилдох шалтгаан үгүй аваас бусдын тусын тулд, буяныг арвижуулахын тулд, сэтгэлийн цэнгэл эдлүүлэхийн тулд үйлдэх хэрэгтэй болой. Энэ тухай “Хөгжмийн шастирын тайлбар”-т “Мөн багш болон чухаг дээд гурвыг тахирын тухайтад олон хүн цугласан цагт, олон хүн харилцан нэг нэгийгээ харахын тулд цугласан цагт, хурим найрын хэргээр олон хүн цугласан газар” (Гантөмөр. 2014:22) дуу эгшиг үүсгэхийг сайшаасан байна. Үүний “олон хүн харилцан нэг нэгийгээ харахын тулд цугласан цагт” гэдгийг эдүгээ цагт нэг талаас дуучид, хөгжимчид тоглолтоо хийх, нөгөө талаас үзэгчид түүнийг нь үзэхээр нэгэн танхим, үзвэрийн газарт цугласантай дүйлгэн ойлгож болно. Мөн хурим найрын хэргээр дуулах, хуурдах уламжлал, ёс заншил нь Монголчуудын дунд нутаг нутаг, ураг удмаараа ялгаатай бөгөөд нэн баялаг тул энд өгүүлж баршгүй. Ямартаа ч хурим, найрын үед дуу, хөгжим үүсгэх нь зүйн хэрэг билээ. “Цугласны дунд өөрөө эгшгийг судалсан нь бага, самбаа нь сул, хамт төрсөн оюун муу” бол мөн зовлон үүтгэхийн шалтгаан болдог байна. Энэ нь дуучин, хөгжимчний өөрийнх нь оюуны бяд, авъяас, ур чадвар, судалгаа, хичээл шамдалтай холбоотой юм. Авъяас, оюун нь төрөлхөөс өгөгддөг хэдий ч түүнийг үргэлж тордон дадуулж, дасгал сургуулилалт хийж байж сая сайн дуучин болно. Тиймээс дасгал маш чухал. “Удаан дуулаагүй хөвчийг өдөр бүр богино дасгалаар дуулж халаах хэрэгтэй. Ер нь дасгалыг аажмаар хүндрүүлэх нь зөв. Дуучинд тавих үндсэн хэд хэдэн гол шаардлага бий. Тухайлбал,

1. Хоолойн ангиллыг зөв тодорхойлсон байх
2. Хөгжмийн тодорхой хэмжээний мэдлэг боловсролтой байх
3. Хэллэгийн арга барилыг эзэмших
4. Дууны өнгө /тембр/, шилжилтийн өнгө, дуучны амьсгал, дуулах ур чадвар, дуулах урлагийн онолын нэр томъёоны талаарх ойлголтуудыг нэлээд дэлгэрэнгүй ойлгож мэдсэн байх зэрэг юм” (Найдалмаа М. 2014:12).

“Бас дуулах урын сандаа зохицуулж хоолойгоо халаах, дасгах хэрэгтэй. Хэрэв дуулах дуу чинь доогуур нооттой байгаад хэт дээгүүр дасгал хийвэл доод өнгө дуугарахгүй болдог. Дасгалыг гурван чиглэлээр хийж хоолойдоо тохируулах хэрэгтэй юм шиг санагддаг. Гэхдээ хүн бүхэн өөрийн онцлог дадал заншилд сурсан, дадсан байдаг л даа.

1. Хоолойн хөвч /связка/ халаах. Аль болох энгийн бөгөөд хоолой шалгах замаар.
2. Өнгө, эгшиг үсэг тэгшитгэх, Вокально зөв болгох.
3. Техникийн янз бүрийн дасгалуудыг хийх. Жишээ нь: Түргэн хэллэг, дуулах нугалаа, хугалаа, чимэг, удаан барих дасгал өдөр бүр хийж байх хэрэгтэй” (Пүрэвдорж, 2003:17) гэх мэтээр дасгалыг хэрхэн хийх тухайд дуулах урлагийн багш¹⁵ нар тус бүрдээ зөвлөсөн байна.

Дасгалаа сайн хийвэл хожим өөртөө зовлон хураахгүй харин ч баяр баясал авчирал тул сайтар хичээх хэрэгтэй. “Сайхан дуулж байгаа дуучдыг сонсохдоо үзэгчид суудлаасаа босох шахаж сэтгэл нь хөдөлж, өөрөөр хэлбэл тэр хүмүүс дуучнаас гоо сайхны таашаал авч баясаж амарч суудаг. Харин муу дуулж /хашгирч, чарлаж, хяхатнаж/ байгаа дуучныг сонсохдоо хэзээ хоолой нь тасрах бол гэж айж эмээж, суудал дороо орох шахаж, яс хавталзаж суудаг” (Пүрэвдорж Ц. 2003:9) бөгөөд дуучинд энэ нь мэдрэгддэг тул өөрөө улам сайн дуулах эсвэл улам муу дуулахад ч дам дамаа нөлөөлнө. Тиймээс хэрэв ийм агшинтай нүүр тулбал маш түргэн засч өөрчлөх, овсгоо самбаатай байх хэрэгтэй. Сайн дуучин бэлтгэхэд дуулах урлагийн багш гол үүрэгтэй бөгөөд энэ тухайд М.Найдалмаа “Сургалт явуулахдаа үндсэн гурван зүйлийг анхаарах ёстой. Үүнд: А. Амьсгалын урлаг, Б. Дуулах ур чадварыг хөгжүүлэх, В. Жинхэнэ ёсоор дуулж сургах /исполнительское мастерство/

¹⁵ Дуучин М.Найдалмаа “Дуулаачийн багш гэж хүний хоолой болох амьд зэмсгийг өөрчлөн түүгээр дамжуулан хүнийг төлөвшүүлж, олон талын мэдлэг, боловсролтой мэргэжлийн дуучин, уран бүтээлчийг төрүүлэх маш их тэвчээр шаардсан чимхлүүр нарийн үйл ажиллагааг эрхэлж буй хүнийг хэлнэ” гэжээ.

нь зүйтэй гэж үздэг. Эхний хоёр нь дуучин хүний гоо зүйн түвшинтэй холбоотой бөгөөд түүний сэтгэлийн хөдөлгөөн, төрөлхийн зөв сайн таашаал, тэдгээрийг сайтар хөгжүүлэх үйл явцаас хамаарахын хамт хөгжмийн сайн зохиолыг байнга судлах, бусад шилдэг дуучин болон багшийн дуулахыг тогтмол сонсож, задлан шинжлэх үйл ажиллагааны үндсэн дээр үнэлгээ дүгнэлт өгөх зэргээс бүрэлдэх юм” (Найдалмаа М. 2014:19) гэжээ. Ийнхүү дасгал, сургуулилалтын үндсэн дээр сурах, судлах, самбаачлах гурвыг сайтар эзэмшин хоёр хөгжмийн агуулгад мэргэжлээс олны дунд оройн чимэг мэт үзэсгэлэнтэй болно.

ДҮГНЭЛТ

Дуучин, хөгжимчин хэн боловч үл зохилдох шалтгаан нь олон бол дуулж хөгжимдөхөөс зайлсхийж сурах, судлахдаа анхаарах хэрэгтэй. Дасгал сургуулилалтаа сайн хийж, овсгоо самбаа гарган сайтар боловсорсон цагт үзэгч, сонсогчид уулга алдан хүлээж авна. Тиймээс дээр дурдсан таван шалтгааныг өөрийнхөө бүтээл туурвил, тоглолт дуулалт бүрдээ хянамгайлан бодож сайны үр нь олон уу, муугийн шалтгаан нь их үү гэдгийг шинж.

Ердийн аж амьдралтай холбоотой хэрэгт үү, хурим найрын үед үү, шашин зан үйлтэй холбоотой үйл үү, олон нийтэд зориулсан тоглолт уу гэдгээс хамааруулан хэзээ, хаана, юуг зөвшөөрдөг, эс зөвшөөрдгийг бодолцон дуу, аягууныхаа найруулга, утга зорилготой нь уялдуул. Учир нь хэрэг явдлын учир, зорилгоос хамааран баримтлах ёс, илэрхийлэх арга нь өөр өөр байна. Мөн дууныхаа үг, эгшиг, утга агуулгыг сайтар судлаж дуул. Эс тэгвээс хочлогдохын уг шалтгаан болохыг санууштай.

THE RESULT OF THE FIVE REASONS [TIBETAN: *RGYU LNGA*]

While we are watching any performance of singers, musicians and actors, we observe their singing, acting and other performances attentively. We can notice their mispronunciations, poor lilts, unnecessary movement and forgetting the lyrics or words due to embarrassment. If they perform them without any fault, we express our inner enjoyment with the roaring applause. The main reason for this is related to how the performer of the sound and melody expresses their knowledge and skill. If they haven't gained enough skill and knowledge as they can't perform as they want to, it is explained in the "Commentary on music treatise" as the concept of "Five reasons". My purpose of this article is to compare the concept of "Five Reasons" with the knowledge, experience and other advices of singing art teachers.

Номзүй

Агваангунгаасодномын /*ngag dbang kun dga' bsod nams*/ Хөгжмийн шастирын тайлбар /*rol mo'i bstan bcos kyi 'drel pa*/ буюу “Хөгжмийн шастир саруул оюунтны сэтгэлийг булаагч үйлсийг огоотод түгээгч” /*Rig pa'i gnas lnga las bzo rig pa'i rol mo'i bstan bcos kyi rnam par bshad pa 'jam dbyangs bla ma dges-pa'i snyan pa'i sgra dbyangs blo gsal yid 'phrog phrin las yongs khyab ces bya ba bzhugs so*/

Дугаржав М. 2008. *Үндэсний дуу хөгжмийг хэрхэн мандуулах тухай*. Монголын хөгжим судлалын дээж бичиг. Уб., х.248-251.

Жанцанноров Н. 1996. *Хөгжмийн нэр томъёоны хураангуй тайлбар толь*. Уб.

Их хүрээний ая эгшгийн уг гарал /*Khu ril chen mo'i dbyangs khungs zhes so*/. Төвөд гар бичмэл.

Найдалмаа М. 2014. Дуулах эрдэм, дуулах урлагийн гарын авлага. УБ.

Пүрэвдорж Ц. 2003. Дуулах ур дүй. УБ.

Хөгжмийн шастир саруул оюунтны сэтгэлийг булаагч үйлсийг огоотод түгээгч. Орч. С.Гантөмөр. 2014. УБ.

Энэбиш Ж. 2008. Үндэсний дуу хөгжмийг хөгжүүлэх талаар М.Дугаржавын дэвшүүлсэн үзэл баримтлалын орчин цагийн ач холбогдол. Монголын хөгжим судлалын дээж бичиг. УБ., х.251-256.

Дууны *youtube* дэх холбоосууд.

https://www.youtube.com/watch?v=FrG110VXo_U 2019. 10. 24

<https://www.youtube.com/watch?v=L1s7VLA9pEI> 2019. 10. 24

<https://www.youtube.com/watch?v=KE83aWBm3PE> 2019. 10. 26

<https://www.youtube.com/watch?v=SSq-oYIIZwk> 2019. 10. 26

<https://www.youtube.com/watch?v=gMexQ8v3zX4> 2019. 10. 26

<https://www.youtube.com/watch?v=0cqguui0LM0> 2019. 10. 26

<https://www.youtube.com/watch?v=Wj8pGO4peCY> 2019. 10. 26

<https://www.youtube.com/watch?v=B7CNQRSRDUQ> 2019. 10. 26

<https://www.youtube.com/watch?v=HfirtBXMyyimg> 2019. 10. 26

<https://www.youtube.com/watch?v=jRwYHLUIYIA> 2019. 10. 26

Зураг 1. “Хөгжмийн шаштирын тайлбар” буюу “Хөгжмийн шаштир саруул оюунтны сэтгэлийг булаагч үйлсийг огоотод түгээгч” зохиолын бүтэц. Энд дугуй улаанаар тэмдэглэсэн хэсэгт 5 шалтгааны тухай өгүүлж байна.

